

**ШИВЭЭ-ОВООГИЙН ХҮРЭН НҮҮРСНИЙ ОРД ГАЗРЫН ШИНЭ-УСНЫ ХЭСГИЙН НӨӨЦИЙГ
ОЛОН УЛСЫН НӨӨЦ, БАЯЛАГИЙН АНГИЛАЛД НИЙЦҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ
ЗӨВЛӨХИЙГ СОНГОХ ТЕХНИКИЙН ДААЛГАВАР**

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Захилагч байгууллагын нэр, хаяг	“Эрдэнэс Монгол” ХХК Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Моннис 14-15 давхар
Төсөл хэрэгжүүлэх талбай	Говьсүмбэр аймаг, Шивээ-Говь сум, Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний орд газар, <i>Тусгай зөвшөөрлийн талбай: MV-013311, MV-013312, MV-013313</i>
Ажлын нэр.	Шивээ Овоогийн хүрэн нүүрсний ордын Шинэ-Усны хэсгийн нөөцийн тайлангийн үнэлгээ, олон улсын нөөц, баялагийн ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээ
Ажил гүйцэтгэх үндэслэл.	“Эрдэнэс Монгол” ХХК нь стратегийн орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах оруулах чиг үүрэг бүхий компани бөгөөд гадаадын хөрөнгийн биржүүдэд болон олон улсын санхүүгийн байгууллагаас санхүүжилт авах, хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах, стратегийн ордуудын нөөцийг олон нийтэд нээлттэй тайлагнахад Монгол улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн нөөц, баялгийн үнэлгээний стандарт нь дан ганц хангалтгүй тул олон улсын хөрөнгийн биржүүдэд хүлээн зөвшөөрөгдсөн, CRIRSCO-ийн нөөц, баялгийг тайлагнах зааврын дагуу ЖОРК стандарт (JORC Code) болон бусад олон улсын нөөц, баялгийн стандартаар ордуудынхаа нөөцийг тайлагнах шаардлагатай. Энэ нь хөрөнгө оруулагч болон компанийн санхүүгийн эрсдэлийг бууруулах ач холбогдолтой.
Ажил гүйцэтгэх үе шат, цар хүрээ.	Шивээ-Овоогийн ордын Шинэ-Усны хэсэгт гүйцэтгэсэн хайгуул судалгааны бүх шатны ажлуудын үр дүнг нэгтгэх, шалгах, баталгаажуулж ЖОРК стандартын дагуу нөөц, баялгийн ангилалд шилжүүлж, нэмэлт хайгуулын ажлыг төлөвлөх, чанарын хяналт, чанарын удирдлагын (QA/QC) хөндлөнгийн хяналт хийх. 1. Өгөгдөл цуглуулах 2. Өгөгдлийн шалгалт, баталгаажуулалт, QA/QC-ийн хөндлөнгийн хяналтын тайлан 3. Өгөгдөлтэй ажиллах аудит хийх 4. Боловсруулалт, хяналт, баталгаажуулалтын ерөмдлөгийн ажлыг төлөвлөх 5. Нөөцийн тооцоо, нөөцийн ангилал - Геостатистик боловсруулалт - Блок загварчлал, нөөцийн тооцоо - Нөөцийн ангилал (Resource classification CRISCO) - Шалгалт (Cross validation) - Харьцуулан бодолт хийх
Чадвар.	ТАВИГДАХ ШААРДЛАГА - Таваас доошгүй ордын нөөц, баялгийг тооцоог CRIRSCO-ийн заавар ЖОРК эсвэл түүнтэй дүйцэхүйц стандартаар хийж байсан туршлагатай байх. <i>Жич: Монголын гурваас доошгүй нүүрсний орд дээр ЖОРК нөөц дээр ажиллаж байсан байх.</i> - Нөөц, баялагийн тайлан боловсруулагч буюу төслийн ахлагч нь AusIMM ба GUUMI (MPiGM)- ийн жинхэнэ гишүүн байна.

-- Гүйцэтгэгч талын баг бүрэлдэхүүнд:

- Уул уурхайн зөвлөх эсвэл мэргэшсэн инженер
- Геотехник инженер (AusIMM жинхэнэ гишүүн)
- Мэргэшсэн геологи инженер эсвэл AusIMM CP геологич багтсан байна.

Техникийн шаардлага.

- Тайланг CRIRSCO-ийн зааврын дагуу JORC стандартад нийцүүлж англи, монгол хэлээр тус бүр үйлдэх.
- Ажлын үе шат бүрд ажлын процедурыг нарийн тусгасан тайлан, зөвлөмж боловсруулна.
- Геологийн нөөц, баялгийн тооцох орчин үеийн албан ёсны эрхтэй программ хангамжтай байх.
- Бусад техникийн нэмэлт шаардлагуудыг захиалагч тал гүйцэтгэгчтэй зөвлөлдөж өөрчилж болно.
- Гүйцэтгэгч тал нь тухайн ажлыг гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөөний дагуу ажиллах

Бусад.

- Ажлыг гүйцэтгэх санхүүгийн чадамжтай байх
- Татвар болон бусад төрлийн өр төлбөргүй байх

ОНЦГОЙ НӨХЦӨЛ

Онцгой нөхцөл.

- Захиалагч тал хяналт шалгалт, явуулах боломжийг бүрэн хангана.
- Геологийн нөөц, баялгийн тооцох орчин үеийн албан ёсны эрхтэй программ хангамжтай байх

Тайлан материал хүлээлгэн өгөх.

- Гүйцэтгэгч тал нь тухайн ажлыг гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөө боловсруулж, танилцуулсан байх
- Бүх шатны ажлыг гүйцэтгэсэн тайлан, зөвлөмж, ажил гүйцэтгэсэн процедур болон бусад анхдагч материал, тоон мэдээлэл, хэвлэмэл зураг зэргийг захиалагч талын хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгнө. (Материал, тайлан хүлээлгэн энэхүү ажлын салшгүй хэсэг юм)
- Бүх шатны загварчлал, боловсруулалтуудын үр дүн зэргийг программын орчинд чөлөөтэй хөрвөж байхаар хүлээлгэн өгнө.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

Ажил эхлэх. Хугацаа.

Ажил гүйцэтгэх гэрээний дагуу